



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/129/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413      Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер:      Д.Эрдэнэчимэг Утас: 70484055      Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a> Аудитор:      П. Ганцолмон Утас: 70157405      Цахим хаяг: <a href="mailto:uliastaivanaudit@gmail.com">uliastaivanaudit@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	8
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	8
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал.....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт.....	11
4.1 Залруулсан алдаа.....	11
4.2 Төлбөрийн акт.....	12
Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогоогүй.....	12
4.3 Албан шаардлага.....	12
4.4 Зөвлөмж.....	12
4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	13

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

9018301, Говь-Алтай аймаг,  
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
E-mail: govialtai@audit.gov.mn

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДЭЛГЭР  
СУМЫН ГУУЛИН БАГИЙН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Ж.ГАНЧИМЭГ ТАНАА

2022.02.25 № 123  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй, нийгмийн даатгалын тайланг тооцоолсон цалингаас илүү тайлагнасан нь, татварын тайлангаар илүү төлөлтэй байгаа нь, гэрэл цахилгаан шуудан холбоо урсгал засварын зардлыг шууд зардлаар бичсэн зэрэг материаллаг 6.2 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалттай нийцэхгүй, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020346


## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>11,045,129.95</b>	<b>14,657,380.94</b>	
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>11,045,129.95</b>	<b>14,657,380.94</b>	
35100	<b>Түүхий эд материал</b>	<b>567,005.94</b>	<b>567,005.94</b>	
35110	Тусгай зориулалттай материал	567,005.94	567,005.94	
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>10,478,124.01</b>	<b>14,090,375.00</b>	
35410	Бичиг хэргийн материал	212,875.00	106,575.00	
35420	Аж ахуйн материал	6,292,784.00	6,190,000.00	
35440	Түлш, шатах тослох материал	1,449,705.01	2,646,000.00	
35450	Барилгын засварын материал	169,000.00	169,000.00	
35460	Хүнсний материал	1,088,940.00	3,713,980.00	
35470	Бусад хангамжийн материал	1,264,820.00	1,264,820.00	
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>332,480,586.91</b>	<b>328,220,170.27</b>	
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>332,480,586.91</b>	<b>328,220,170.27</b>	
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>328,613,920.23</b>	<b>324,353,503.59</b>	
39201	Барилга, байгууламж, орон сууц	360,955,000.00	360,955,000.00	
39202	Хуримтлагдсан элэгдэл	(46,320,166.64)	(49,236,833.30)	
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	45,237,312.00	45,237,312.00	
39206	Хуримтлагдсан элэгдэл	(34,040,811.79)	(34,990,811.77)	
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,586,800.00	27,586,800.00	
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,005,758.34)	(26,399,508.34)	
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,232,722.40	7,232,722.40	
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,232,722.40)	(7,232,722.40)	
39217	Нөм	1,201,545.00	1,201,545.00	
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>3,866,666.68</b>	<b>3,866,666.68</b>	
39301	Програм хангамж	168,000.00	168,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(168,000.00)	(168,000.00)	
39303	Бусад биет бус хөрөнгө	4,000,000.00	4,000,000.00	
39304	Хуримтлагдсан элэгдэл	(133,333.32)	(133,333.32)	
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>343,525,716.86</b>	<b>342,877,551.21</b>	
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>343,525,716.86</b>	<b>342,877,551.21</b>	
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>343,525,716.86</b>	<b>342,877,551.21</b>	
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	47,480,636.00	47,480,636.00	
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>294,494,940.83</b>	<b>293,846,775.18</b>	
51210	Өмнөх үеийн үр дүн	309,003,481.81	294,494,940.83	
51220	Тайлант үеийн үр дүн	(14,508,540.98)	(648,165.65)	
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,550,140.03	1,550,140.03	
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>343,525,716.86</b>	<b>342,877,551.21</b>	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/Төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	184,737,250.00	160,266,180.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,588,320.00	546,580.00
120	Нийтлэг татварын бус орлого	6,588,320.00	546,580.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,588,320.00	546,580.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,588,320.00	546,580.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	178,148,930.00	159,719,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	166,864,930.00	147,101,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	166,864,930.00	147,101,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	388,800.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	388,800.00	0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	10,895,200.00	12,618,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,895,200.00	12,618,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	199,245,790.98	160,914,345.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	199,245,790.98	160,914,345.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	174,869,638.51	158,688,813.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,812,476.53	116,474,293.88
210101	Үндсэн цалин	97,181,648.61	93,009,710.14
210104	Урамшуулал	8,426,486.90	9,578,191.91
210105	Гэрээт ажлын хөлс	13,204,341.02	13,886,391.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,545,195.00	16,897,017.03
210201	Тэтгэврийн даатгал	12,063,940.58	12,299,429.00
210202	Тэтгэмжийн даатгал	472,500.00	1,138,087.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,069,080.19	955,546.40
210204	Ажилгүйдлийн даатгал	267,192.71	232,338.54
210205	Эрүүл мэндийн даатгал	2,672,481.52	2,271,616.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,413,136.00	8,063,037.08
210301	Гэрэл, цахилгаан	1,168,036.00	1,345,332.07
210302	Түнш, халаалт	8,165,100.00	5,707,705.01
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,472,050.00	3,379,280.00
210401	Бичиг хэрэг	259,000.00	305,300.00
210402	Тээвэр, шатахуун	569,600.00	352,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	330,000.00
210404	Нөм, хэвлэл	0	37,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	188,450.00	2,263,380.00
2105	Нормативт зардал	5,182,810.52	5,985,585.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,500.00	370,000.00
210502	Хоол, хүнс	5,162,310.52	5,518,285.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	97,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,307,100.00	2,665,184.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	190,500.00	23,400.00
210604	Урсгал засвар	2,116,600.00	2,641,784.00
2107	Томилолт, зочны зардал	196,000.00	126,000.00
210702	Дотоод албан томилолт	196,000.00	126,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	436,000.00	768,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,504,870.46	4,340,416.64
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,000.00	80,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	20,474,870.46	4,260,416.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,376,152.47	2,226,532.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	959,800.00	400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	959,800.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	215,664.00	15,167.93
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,664.00	15,167.93
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,200,688.47	1,810,364.09
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,200,688.47	1,810,364.09
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-14,508,540.98	-648,165.65
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИИТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-14,508,540.98	-648,165.65

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	309,003,481.81	358,034,257.84
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	309,003,481.81	358,034,257.84
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(14,508,540.98)	(14,508,540.98)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	294,494,940.83	343,525,716.86
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	294,494,940.83	343,525,716.86
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	294,494,940.83	343,525,716.86
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(648,165.65)	(648,165.65)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	47,480,636.00	1,550,140.03	293,846,775.18	342,877,551.21

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/Төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>178,148,930.00</b>	<b>159,719,600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>178,148,930.00</b>	<b>159,719,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>166,864,930.00</b>	<b>147,101,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	166,864,930.00	147,101,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>388,800.00</b>	<b>0.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	388,800.00	0.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>10,895,200.00</b>	<b>12,618,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	10,895,200.00	12,618,000.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>178,148,930.00</b>	<b>159,719,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>178,148,930.00</b>	<b>159,719,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>153,772,777.53</b>	<b>157,494,067.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>118,842,676.53</b>	<b>116,038,206.41</b>
210101	Үндсэн цалин	97,161,848.61	93,009,710.14
210104	Урамшуулал	8,476,486.90	9,578,191.91
210105	Гэрээт ажлын хөлс	13,204,341.02	13,450,304.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>16,494,995.00</b>	<b>16,981,949.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	12,013,940.58	12,299,429.00
210202	Тэтгэмжийн даатгал	472,500.00	1,138,087.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,068,980.19	955,546.40
210204	Ажилгүйдлийн даатгал	267,192.71	232,338.54
210205	Эрүүл мэндийн даатгал	2,672,381.52	2,356,548.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,282,536.00</b>	<b>10,689,332.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	1,168,036.00	2,489,332.07
210302	Түлш, халаалт	8,034,500.00	7,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	80,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,990,400.00</b>	<b>1,142,600.00</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	569,600.00	352,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	330,000.00
210404	Ном, хэвлэл	45,000.00	49,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	155,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	820,800.00	220,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>4,758,170.00</b>	<b>9,066,480.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	152,500.00	610,000.00
210502	Хоол, хүнс	4,455,670.00	8,356,480.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,637,000.00</b>	<b>2,151,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	238,000.00
210604	Урсгал засвар	1,397,000.00	1,913,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>196,000.00</b>	<b>126,000.00</b>
210702	Дот оод албан томилолт	196,000.00	126,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>436,000.00</b>	<b>768,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	648,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	0.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>135,000.00</b>	<b>530,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	135,000.00	530,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,376,152.47</b>	<b>2,225,532.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>959,800.00</b>	<b>400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	959,800.00	400,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>215,664.00</b>	<b>15,167.93</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,664.00	15,167.93
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>23,200,688.47</b>	<b>1,810,364.09</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	23,200,688.47	1,810,364.09

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>159,719,600.00</b>	<b>157,894,067.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>159,719,600.00</b>	<b>157,894,067.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>159,319,600.00</b>	<b>157,494,067.98</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>116,674,000.00</b>	<b>116,038,206.41</b>
210101	Үндсэн цалин	92,009,000.00	93,009,710.14
210104	Урамшуулал	8,822,000.00	9,578,191.91
210105	Гэрээт ажлын хөлс	15,843,000.00	13,450,304.36
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>17,946,000.00</b>	<b>16,981,949.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	14,007,000.00	12,299,429.00
210202	Тэтгэмжийн даатгал	984,000.00	1,138,087.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	788,000.00	955,546.40
210204	Ажилгүйдлийн даатгал	197,000.00	232,338.54
210205	Эрүүл мэндийн даатгал	1,970,000.00	2,356,548.53
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>10,700,000.00</b>	<b>10,689,332.07</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,500,000.00	2,489,332.07
210302	Түлш, халаалт	7,200,000.00	7,200,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,000,000.00	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,142,800.00</b>	<b>1,142,600.00</b>
210401	Бичиг хэрэг	100,000.00	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	352,800.00	352,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	330,000.00	330,000.00
210404	Ном, хэвлэл	50,000.00	49,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	90,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	220,000.00	220,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>9,259,200.00</b>	<b>9,066,480.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	630,000.00	610,000.00
210502	Хоол, хүнс	8,529,200.00	8,356,480.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,158,000.00</b>	<b>2,151,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	240,000.00	238,000.00
210604	Урсгал засвар	1,918,000.00	1,913,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>141,600.00</b>	<b>126,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	141,600.00	126,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>768,000.00</b>	<b>768,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	120,000.00	120,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	648,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>530,000.00</b>	<b>530,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	530,000.00	530,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>400,000.00</b>	<b>400,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>159,719,600.00</b>	<b>159,719,600.00</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>147,101,600.00</b>	<b>147,101,600.00</b>
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	147,101,600.00	147,101,600.00
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>12,618,000.00</b>	<b>12,618,000.00</b>
320001	Орон нутгийн төсвөөс	12,618,000.00	12,618,000.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлгэр сумын гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аудитын “Улиастай ван аудит” ХХК-ийн аудитор П.Ганцолмон гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлгэр сумын гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 12-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус цэцэрлэг нь тайлант оны хичээлийн жилд мэргэшсэн чадварлаг баг, сургалт хөгжлийн ээлтэй орчиноор бага насны хүүхдийн хөгжлийг дэмжсэн бүс нутгийн тэргүүлэх цэцэрлэг байх зорилго тавьсан.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахаар даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 154.3 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.5 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын дүн болох 160.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.6 сая төгрөгөөр шинэчлэн тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.19 хувиар буюу 0.6 сая төгрөгөөр буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 14.7 сая төгрөг болж 3.6 сая төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, түлш шатах тослох материал, хүнсний материал нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 20.6 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 0.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 17.5 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 446.4 сая төгрөг ба тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй, эцсийн үлдэгдэл 446.4 сая төгрөг байна

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 342.9 сая төгрөг болж 0.6 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 13.2 хувиар буюу 29.4 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлоготой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 293.8 сая төгрөг болсон байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аудитын код: ГАА-2022/129/-НА-СТА-ТШЗ

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 168.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 8.3 сая төгрөгөөр бууруулж, 159.7 сая төгрөгөөр баталжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 7 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 159.7 төгрөгийн төсөв баталснаас 147.1 сая төгрөгийг улсын төсвөөс 12.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 147.1 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 12.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 157.9 сая төгрөгийг зарцуулж, 1.8 сая төгрөгийг улсын төсөвт, 0.02 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 157.8 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 0.7 сая төгрөгөөр, норматив зардлыг 0.2 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 1.0 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлан онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого хүлээн аваагүй.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 185.8 сая төгрөгийн 45 мэдээллээс 185.8 сая төгрөгийн 45 мэдээллийг ил тод бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4. таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ

### 3.9.2 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилт

Худалдан авалтын 0.8 сая төгрөгийн и баримтыг цахимд шивүүлээгүй байсныг нөхөн шивүүлсэн нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 11.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснээс 11.9 сая төгрөгийн албан шаардлага биелүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараа жилийн аудитаар:

- Бараа материалын үлдэгдлийг тулган баталгаажуулах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 0.8 сая төгрөгийн алдааг залруулж, 5.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

#### 4.1 Залруулсан алдаа

- Худалдан авалтын 0.8 сая төгрөгийн и баримтыг цахимд шивүүлээгүй байсныг нөхөн шивүүлсэн

#### 4.2 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 4.3 Албан шаардлага

- Жолоочийн тооцооны хуудсыг журмын дагуу хөтлөөгүй, тооцоо бодоогүй 0.3 сая төгрөгийн шатахуун олгосон нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй байгаа нь: Засгийн газрын 2021 оны " төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар"43 дугаар тогтоолын 1.1-д" Үндсэн үйл ажиллагаатай холбоотой , зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсвөөс , арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал, болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөж хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Нийгмийн даатгалд 0.9 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь: Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 1. "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Татварын тайлангаар 1.6 сая төгрөгийн илүү төлөлттэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.
- Тайлант онд 2.6 сая төгрөгийн зардлыг тооцооны дансаар дамжуулаагүй шууд зардалд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Аж ахуй нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккурэл сууриар хөтөлнө" заалт, мөн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ,14.3.1.анхан шатны баримт бүрдүүлэх, 14.3.2.журналд бичих, 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх, 14.3.4.ажил, гүйлгээний мэдээ гаргах, 14.3.5.санхүүгийн тайлан гаргах. УСНББОУС1, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

#### 4.4 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй.

Аудитын код: ГАА-2022/129/-НА-СТА-ТШЗ

**4.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Дэлгэр сумын Гуулин багийн хүүхдийн цэцэрлэг	6	6.2	1	0.8	0	0	5	5.4	0	0

Аудитын код: ГАА-2022/129/-НА-СТА-ТШЗ